

МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ

2015.05

Үзүүлэлтүүд:

ДНБ 4.4%	ГШХО 4-р сард 37.3 сая ам.доллар	Төсвийн тэнцэл (347.7) тэр бум төгрөг	Инфляци 8%	Чанаргүй зээл 738.6 тэрбум төгрөг	Валютын нөөц 1267.3 сая ам.доллар
Өсөлтөнд ХАА салбар 9.2%, аж үйлдвэр, барилгын салбар 13.1%, үйлчилгээний салбар 3.3%-иар өссөн нь нөлөөлжээ.	Цэвэр ГШХО 4-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 сая ам.доллараар буурч, өмнөх сараас 69.1 сая ам.доллараар өсч 37.3 сая ам.доллар болов.	Төсвийн орлого 2.09 их наяд төгрөг, зарлага 2.44 их наяд төгрөг, тэнцэл 347.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.	Өмнөх сараас 0.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8 хувиар өслөө.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 8.4 тэрбум төгрөг буюу 1.1%-иар буурч 738.6 тэрбум төгрөгт хүрэв.	Монголбанкны валютын нөөц өмнөх сараас 4.3 хувь буюу 56.6 сая ам.доллараар буурч 1267.3 сая ам.долларт хүрэв.



Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш
1939.3



Орон сууцны үнийн индекс
1.168
Өмнөх сараас 0.207%-иар өсч, өмнөх жилээс 5.362%-иар буурлаа.



Монголбанкны бодлогын хүү
1%-иар нэмэгдэж
13%




Худалдаа хөгжлийн банк МУ-ын Засгийн газрын баталгаатай, дунд хугацааны 500 сая ам.долларын бондоо дэлхийн санхүүгийн зах зээлд 2015 оны 5-р сарын 19-нд амжилттай арилжааллаа.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, оны эцсийн байдлаар хүснэгтээр үзүүлээ.

Эх сурвалж: УСХороо



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2012 он		2013 он		2014 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	20574	1 880 396	18 194	1 116 153	1 106	850 615
Төмрийн хүдэр	6415	532 509	6725	654 333	8 338	448 378
Зэсийн баяжмал	575	838 780	650	948 951	1 378	2 575 636
Нийт	27564	3 251 685	25 569	2 719 437	10 822	3 874 629

Эх сурвалж: УСХороо



Монгол Улсын Засгийн газар болон уул уурхайн “Рио Тинто” групп далд уурхайн санхүүжилт, татварын маргаантай холбоотой хоёр жил үргэлжилсэн маргаанаа шийдвэрлэсэн байна.


ДНБ

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2015 оны эхний улиралд 2.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 119.6 тэрбум төгрөг буюу 4.4 хувиар өслөө. Үүнд ХАА-н салбар 9.2 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 13.1 хувь, үйлчилгээний салбар 3.3 хувиар тус тус өссөн нөлөөлжээ.



Төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ тавдугаар сард 2.09 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 2.44 их наяд төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 347.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 240.7 тэрбум төгрөг буюу 248.4 хувиар өссөн байна.




Валютын хани

Тавдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 1939.28 төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 126.2 төгрөг буюу 7 хувь суларч, өмнөх сараас 36.5 төгрөгөөр буюу 1.8 хувиар чангарсан байна.



Инфляци

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2015 оны тавдугаар сард өмнөх сарынхаас 0.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8 хувиар өслөө. Индекс өмнөх сарынхаас 0.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, хувцас, бөс, бараа, гутлын бүлгийнх 0.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, МБ

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2015 оны дөрөвдүгээр сарын байдлаар 1267.3 сая ам.доллар байв. Энэ нь өмнөх сараас 4.3 хувь буюу 56.6 сая ам.доллараар, өнгөрсөн оны мөн үеэс 23.2 хувь буюу 60.5 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлт юм. Монголбанкинд алт тушаалтын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 13 хувиар буурч 895.4 кг болсон байна.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс


Үнэт цаасны арилжаагаар 2015 оны эхний 5 сард 481.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 16.6 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 376 тэрбум төг буюу 4.6 дахин, арилжигдсан үнэт цаас 780.9 мян ш буюу 4.9 хувиар өссөн байна. ТОП-20 дундаж индекс 2015 оны 5 дугаар сард 12805.2 болж, өмнөх сарынхаас 308.5 нэгжээр буурчээ. Хөрөнгийн бирж үйл ажиллагаа явуулж байгаа ХК-иудын үнэт цаасны нийт үнэлгээ 5 дугаар сард 1.3 их наяд төг болж, өмнөх сарынхаас 27.6 тэрбум төг буюу 2.2 хувиар буурчээ.



*Монголын хөрөнгийн бирж

Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны тавдугаар сарын эцэст 9.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 134.5 тэрбум төгрөг буюу 1.4%-иар, өмнөх оны мөн үеэс 401 тэрбум төгрөг буюу 3.9 %-иар тус тус буурчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тавдугаар сард 793.7 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 58.8 тэрбум төгрөг буюу 8%-иар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 69.3 тэрбум төгрөг буюу 8%-иар буурсан байна.



Хадгаламж

Нийт хадгаламж 2015 оны тавдугаар сард 7.1 их наяд төгрөг болж, өнгөрсөн сараас 81.8 тэрбум төгрөг буюу 1.1 хувиар буурчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 16.2 тэрбум төгрөг буюу 0.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Ийнхүү өмнөх сараас нийт хадгаламж буурахад төгрөгийн хадгаламж 1.7 хувиар буюу 88.2 тэрбум төгрөгөөр өсөж, валютын хадгаламж 8.1 хувиар буюу 170 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны тавдугаар сарын байдлаар 12.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 126.9 тэрбум төгрөг буюу 1%-иар буурч, өмнөх оны мөн үеэс 104.9 тэрбум төгрөг буюу 0.9%-иар өслөө. Харин чанаргүй зээлийн хэмжээ 738.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.1% (8.4 тэрбум төгрөг)-иар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 19.2% (118.8 тэрбум төгрөг) өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 6.1%-ийг эзэлж байна.



Ипотекийн зээл

2015 оны тавдугаар сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 1.5 хувь (45.2 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 32.2 хувь (762.5 тэрбум төгрөг) - иар нэмэгдэж нийт 3.13 их наяд төгрөгт хүрэв. Тавдугаар сард нийт 1454 зээлдэгчид 82.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 71355-д хүрлээ. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.3 хувь нь төгрөгийн, 1.7 хувь нь гадаад валютын зээл байгаа бөгөөд нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээл 0.6 хувийг эзэлж байна




* Эх сурвалж Монголбанк

Гадаад худалдаа

Гадаад худалдаа


2015 оны тавдугаар сард худалдааны нийт бараа эргэлт 3316.2 сая ам.доллар, үүнээс экспорт 1869.3 сая ам.доллар, импорт 1447.0 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 422.3 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 700.9 сая ам.доллар буюу 17.4 хувь, үүний дотор импортын хэмжээ 648.9 сая ам.доллар буюу 31.0 хувиар, экспортын хэмжээ 52 сая ам.доллар буюу 2.7 хувиар тус тус буурчээ. Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 52 сая ам.доллар буюу 2.7%-иар буурахад эрдэс, нэхмэл бүтээгдэхүүнүүдийн экспорт буурсан нь нөлөөлж, импорт буурахад төмөрлөг бүтээгдэхүүн, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг гэх мэт бүтээгдэхүүний импорт буурсан нь голлон нөлөөлөв.



* Эх сурвалж ҮСХ, МБ

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2015 оны дөрөвдүгээр сард 37.3 сая ам.долларын эерэг дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 10 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. 4-р сард МУ-аас гарсан хөрөнгө оруулалт 1.1 сая ам.доллар байсан бол МУ-д 38.4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ. 2014 оны 10 сараас хойш хөрөнгө оруулалтын цэвэр дүн сөрөг утгатай гарч байсан бөгөөд энэ оны дөрөвдүгээр сард эерэг дүнтэй гарсан нь МУ-д хийгдэх хөрөнгө оруулалт нэмэгдэх хандлагыг харуулж байгаа билээ.



* Эх сурвалж МонголБанк

Монгол Улсын гадаад өр, зээлжих зэрэглэл

Гадаад өр

Засгийн газрын нийт гадаад өр 3.6 тэрбум ам.доллар байна.

2014 оны эцсийн байдлаар Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 20.9 тэрбум ам.доллар байсан. Энэ нь өмнөх оны мөн үеэс 10 хувь (1.9 тэрбум ам.доллар) өссөн бол өмнөх улирлаас 0.04 хувь (8.2 сая ам.доллар) буурсан байна.

Нийт өрийн 17 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны өр, 8 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 17 хувийг бусад салбаруудын өр, 51 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

Төв банкны нийт өрийн 95 хувийг богино хугацаат, 5 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



* Эх сурвалж Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төсөөлөл

Тэрбум төгрөг

Үзүүлэлтүүд	2014.09.3 Гүйцэтгэл	2015 он	2016 он	2017 он
ЗГ-ын гадаад зээлийн өр	3,911.50	4,089.20	4,299.10	4,169.30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2,760.80	2,625.00	2,550.00	2,490.00
Засгийн газрын баталгаа	2,305.50	2,515.80	2,439.20	1,312.50
Засгийн газрын гадаад өрийн дүн	8,977.80	9,230.00	9,288.30	7,971.80

* Эх сурвалж Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

Гадаад өр, зээлжих зэрэглэл

Зээлжих
зэрэглэл

Монгол Улс	S&P		Fitch	
	B+	Тогтвортой	B+	Сөрөг
Огноо	2014.04.29		2013.12.13	

Standard & Poor's 2014 оны 4-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлд өөрчлөлт оруулж урт хугацаанд “BB-” байсныг “B+” болгон бууруулж, богино хугацааны зээлжих зэрэглэлийг “B” болгон тогтоосон. Үүнээс өмнө манай улсын зээлжих зэрэглэл “BB+” гэсэн ангилалд багтаж байсан билээ. S&P : МУ-ын зээлжих зэрэглэлд 2014 оны дөрөвдүгээр сараас хойш өөрчлөлт гараагүй байна. Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан шалтгааныг тэд гадаадын хөрөнгө оруулалт 50 орчим хувиар буурсан, гадаад валютын урсгал багассан, өрийн ачаалал үүсч болох эрсдэлт нөхцөл үүссэнтэй холбон тайлбарлаж байна.

Moody's :

Moody's агентлаг нь зээлжих зэрэглэлийг тогтоохдоо C ангиллаас AAA хүртэл 21 ангилалд зэрэглэл тогтоодог ба мөн хэтийн төлөвийг сөрөг, тогтвортой гэж үнэлдэг юм.

Огноо	Зээлжих зэрэглэл	Хэтийн төлөв
2005 оны 10 дугаар сар 4-нд	B1	Тогтвортой
2009 оны 6 дугаар сарын 10-нд	B1	Сөрөг
2009 оны 10 дугаар сарын 30-нд	B1	Тогтвортой
2014 оны 5 дугаар сарын 26-нд	B1	Сөрөг
2014 оны 7 дугаар сарын 17-нд	B2	Сөрөг

Moody's өнгөрөгч оны 7-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан.

Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B1 -ээс B 2 сөрөг болгож бууруулсан. Үүний шалтгааныг Монгол Улсын гадаад өрийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өссөн, инфляци өндөр байгаа нь чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж, банкны системийг бүхэлд нь эрсдэлд оруулах магадлалтай гэж үзжээ. Түүнчлэн гадаад валютын нөөц буурч байгааг эрсдэлд тооцжээ.

Үүний зэрэгцээ Moody's засгийн газрын үнэт цаас гаргагч ба бондын үнэлгээг B1, засгийн газрын дунд хугацаат өрийн бичгийн үнэлгээг B1, мөн богино хугацааны үнэлгээг "not prime" буюу төлбөрийн чадвар сул зэрэглэлд хэвээр үлдээсэн.

Уг шийдвэртэй холбоотойгоор тус агентлагийн зүгээс Монголын Засгийн газрын эзэмшлийн Хөгжлийн банкны зэрэглэлийн ирээдүйн төлөвийг тогтвортойгоос сөрөг болгон бууруулсан ба Хөгжлийн банкны хоёрдогч өглөгийг B1, хоёрдогч дунд хугацаат өрийн бичгийг B1 гэж үнэлсэн юм. 2015 оны гуравдугаар сард Moody's МУ-ын арилжааны банкуудын зээлжих зэрэглэлийн тайланг гаргажээ. Энэхүү тайланг www.moodys.com сайтаас нь татах боломжтой.

* Эх сурвалж <http://www.moodys.com/>
<http://www.standardandpoors.com/>
<http://www.fitchratings.com/>

Сарын онцлох үйл явдал

- 05.13** БСШУЯ, ШУТИС, НЗДТГ, Аж үйлдвэрийн яам, Мэдээлэл технологийн үндэсний парк, Монголын Инновацийн холбоо, МХАҮТ, Монголын технологийн холбоо хамтран зохион байгуулж буй Инновацийн долоо хоногийн хүрээнд "Инновацийн үндэсний форум" тавдугаар сарын 13-нд төрийн ордонд болллоо. Нийгэм-эдийн засгийн хүрээнд инновацийн соёлыг төлөвшүүлж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх инновацийн түншлэлийг өргөжүүлэх зорилгоор “Монголын инновацийн долоо хоног” арга хэмжээг тус форумгаар эхлүүлж байгаа юм.
- 05.15-05.16** Нүүрсний “цэвэр” технологийг олон улсад таниулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх зорилготой “World Clean Coal” олон улсын бага хурал Монгол Улсад 2 дахь жилдээ зохион байгуулагдлаа. Нүүрсний “цэвэр” технологийг олон улсад таниулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх зорилготой олон улсын бага хурал нь байгаль орчинд хор хөнөөлгүй технологийг ашиглан нүүрсийг боловсруулах туршлагатай компаниуд энэхүү арга хэмжээнд чуулдаг байна. Энэ жилийн чуулганы үйл ажиллагаанд гадаад, дотоодын 100 орчим төлөөлөгчид оролцож, “Clean Coal” хурал нь хоёр өдрийн турш чуулж өндөрлөлөө.
- 05.19** Монгол Улсын Засгийн газар болон уул уурхайн “Рио Тинто” групп далд уурхайн санхүүжилт, татварын маргаантай холбоотой хоёр жил үргэлжилсэн маргаанаа 2015 оны тавдугаар сарын 19-ны өдөр шийдвэрлэсэн. Маргааныг шийдвэрлэх явцад “Turquoise Hill” компани хэд хэдэн асуудал дээр буулт хийсэн байна.
- 05.19-05.21-нд** Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн Арабын Нэгдсэн Улсын Эмират улсад 2015 оны тавдугаар сарын 19-21-ний өдрүүдэд ажлын айлчлал хийлээ. Айлчлалын үеэр “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-г баталж гарын үсэг зуржээ.

Тойм**“Turquoise Hill” компани нь доорх асуудлуудад буулт хийжээ.**

“Turquoise Hill” нөөц ашигласны төлбөртэй холбоотой асуудалд буулт хийж, боловсруулах болон тээврийн зардлыг хассан орлогоос хоёр хувийг хайлуулах үйлдвэрийн ашиглалтын төлбөр болгон Монголд төлнө.

“Оюу толгой”-н борлуулалтын орлогоос таван хувийг Монголд төлөх ёстой байсныг өөрчилж ямар нэг зардал суутгалгүйгээр нийт орлогоос таван хувийг тооцон төлнө гэжээ.

Монголын татварын байгууллагаас гаргасан анхны тооцоогоор “Turquoise Hill” компани 127 сая ам.доллар төлөхөөр гарсан ч үүний оронд 30 сая ам.доллар төлөхөөр болж, хоёр тал татварын маргааныг шийдвэрлэжээ. “Оюутолгой”-н баялгийн 80 гаруй хувь байгаа гүний уурхайн ажлыг өрнүүлэхэд зургаан тэрбум ам.доллар шаардлагатай. Үүний дийлэнх хувь буюу дөрвөн тэрбум ам.долларын санхүүжилтийн багцыг дэлхийн 10 гаруй банк бүрдүүлээд байгаа хэмээн “Turquoise Hill” компани мэдэгдээд байна.

Худалдаа Хөгжлийн банк Кастодиан үйлчилгээг нэвтрүүллээ.

ХХБ Монголын хөрөнгийн зах зээлд анх удаа Кастодиан үйлчилгээг нэвтрүүллээ. Кастодиан үйлчилгээг нэвтрүүлснээр олон улсын кастодиан банкуудтай харилцах боломж бүрэн нээгдэх бөгөөд энэ утгаар хөрөнгө оруулалтын шинэ урсгал бий болох хөрөнгийн зах зээлийг олон улсад нээх томоохон боломжууд нээгдэх боломжтой.

